



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,  
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160-0066  
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809  
Цахим шуудан: contact@ub-procurement.mn  
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.11.15 № 03/2141

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдөр зарласан НХААГ/20240102633 дугаартай "Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн нэгдсэн эмнэлэгт шаардлагатай тоног төхөөрөмж (Улаанбаатар хот)" нийлүүлэх тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдээс тендер шалгаруулалтын баримт бичигтэй холбогдуулан ирүүлсэн тодруулгын хариуг хүргүүлж байна.

№	Сонирхогч этгээдийн тодруулга	Захиалагчийн хариу
1	Тендерийн бичиг баримтын техникийн үзүүлэлтэд 3 өөр багц болгон хуваасан боловч бичиг баримтад багцгүй гэж заасан байна. 4 нэр төрлийн тоног төхөөрөмжүүд нь хэрэглээ, зориулалт өөр учир багц болгон оруулах нь зүйтэй юм. Багцтай эсэхийг тодруулж өгнө үү.	Тус нээлттэй тендер шалгаруулалтыг 3 багцад хувааж өөрчилсөн болно. Та бүхэн шинэчилсэн тендер шалгаруулалтын баримт бичигтэй Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр орж танилцана уу.
2	Тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 1.2-д тус тендерийг багцгүй гэж заасан боловч тендерийн техникийн тодорхойлолтод тоног төхөөрөмжийг 3 багцад хуваасан байна. Дээрх тоног төхөөрөмжүүдийн хэрэглээ, зориулалт өөр учир багц болгон оруулах нь зүйтэй гэж үзэх байна. Иймээс тухайн тендерийг багцтай эсэхийг тодруулж өгнө үү.	
3	Манай компани нь Диализийн аппарат, усны төхөөрөмжийг улс даяар нийлүүлж байсан туршлагатай бөгөөд дээрх тендерийн багцад Диализын аппарат, усны төхөөрөмж дээр зөвхөн Mindray фирмийн аппарат хэрэгслүүдийг нийлүүлээд багцалсан байна. - Mindray фирм нь Монгол улсад хоёрхон төлөөлөгчтэй байгаа нь	-Захиалагчийн хяналт тавих байгууллагаас шинэчлэн баталсан Багц-1 дэх тоног төхөөрөмж болох Гемодиализын эмчилгээний аппарат, Гемодиализын эмчилгээний аппаратын зөөврийн усны цэвэршүүлэх систем (RO) техникийн тодорхойлолтыг хавсралтаар оруулав. Мөн Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем дэх тус тендер шалгаруулалтын "ТЭЗҮ" хэсэгт оруулсан болно. Бусад тоног төхөөрөмжийн техникийн

<p>өрсөлдөх боломжийг олгохгүй байна.</p> <p>- Иймд дээрх багцыг салгаж өгч өрсөлдөх боломжоор хангаж өгнө үү</p>	<p>тодорхойлолтыг шинэчлэн батлуулж, оруулсан болно. Мөн тоног төхөөрөмжүүдийг тус тусад 3 багц болгон өөрчилсөн болно.</p>
---	---

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэгт заасны дагуу дараах өөрчлөлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт оруулж байна.

№	Өмнөх заалт	Өөрчилсөн заалт
1	<p>Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 26.1, 26.2 дахь хэсэг.</p> <p>-Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 10 цаг 00 минут;</p> <p>-Тендерийн нээлт: 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 10 цаг 30 минут гэснийг;</p>	<p>-Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 14 цаг 00 минут;</p> <p>-Тендерийн нээлт: 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 14 цаг 30 минут гэж өөрчлөв.</p>

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.



Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар  
Удирдлага  
Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч  
Даваадорж Батцэцэг  
2024.11.15 14:41